



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023-2027

АГУУЛГА

		Хуудас
НЭГ.	БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ХОЁР.	БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТЭМҮҮЛЭЛ	5
ГУРАВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД, ЛОГИК ХОЛБОО	6
ДӨРӨВ.	БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2023 – 2028 ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	7
ТАВ.	СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН	10

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн 1956 онд үүсэн байгуулагдаж, эрдэм шинжилгээ, боловсрол, сургалт-арга зүйн ажлыг тасралтгүй 70 орчим жил үр дүнтэй явуулж буй манай улсын эрдэм судлалын ууган байгууллагуудын нэг билээ. Тэр үеэс хойш өнөөг хүртэл Монгол Улсын сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, шинэчлэн сайжруулахад гол чиглүүлэг залуур болж, бүх түвшний боловсролын сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин, сурах бичгийн шинжлэх ухааны үндэслэлийг судлан боловсруулах, багшийн мэргэжил дээшлүүлэх, хүүхэд өсвөр үе, залуучууд, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулж байсныг онцлон тэмдэглэж байна.

Түүнчлэн шинэ зууны боловсролын үзэл санаа, өөрчлөлтийн чиг хандлага, тавигдаж буй шаардлага, шинэчлэн батлагдсан хууль эрх зүйн хүрээнд манай хүрээлэнгийн бүтэц-зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэг улам боловсронгуй болж, нарийвчлагдаж байна.

Үүний тод жишээ бол манай хүрээлэн нь Монгол Улсын боловсролын хөгжлийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад судалгааны мэдээллээр хангах, нотолгоонд суурилсан салбарын бодлого төлөвлөлт, эдийн засаг, менежмент, хүний хөгжил болон сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүн, боловсролын ирээдүйн хөгжлийн чиг хандлагын чиглэлээр суурь болон хавсарга судалгаа-шинжилгээ, инновац, арга зүйн ажил эрхлэх, байгууллага, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр хангах замаар хүний хөгжилд хувь нэмэр оруулахад гол зорилго оршиж байгаа болно.

Бид Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, үнэ цэнийг өндөржүүлэх, судалгааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлого, чиглэл, төлөвлөлтийг сайжруулах, улам илүү чанаржуулах зорилгоор байгууллагын стратеги төлөвлөгөө (2023-2027)-г боловсрууллаа.

Ингэхдээ “Боловсролын хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөө 2018-2022”-ний хэрэгжилтэд үнэлгээ хийж, туршлага, сургамжийг үндэслэн дөрвөн үе шаттайгаар зохион байгууллаа. Үүнд:

I үе шат (өнөөгийн байдлын): байгууллагын чадамжийн шинжилгээ, стратегийн бэлэн байдлын шинжилгээ, асуудлын шинжилгээ хийж эхний төлөв байдлыг тодорхойлсон.

II үе шат (системийн шинжилгээ): макро орчны бодлогын, эрх зүйн, хүн ам зүйн, нийгэм соёлын, технологийн судалгаа; микро орчны хэрэглэгч, хамтрагч, дэмжигчийн судалгаа хийж SWOT, MECSON, CROSS шинжилгээ хийсэн.

III үе шат (стратеги төлөвлөгөөний эхний хувилбар): Дээрх шинжилгээнд суурилан эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, баримтлах зарчмаа тодорхойлон, хүрээлэнгийн хөгжлийн зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг томъёолж, нийт ЭША, албан хаагчдаас хэлэлцүүлж, санал авч тусгасан.

IV үе шат (стратеги төлөвлөгөөний нарийвчилсан хувилбар): Хөгжлийн замын зураг, хамтын ажиллагааны төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, хариуцах эзэн, хугацаа, өртөг зардал, менежментийг баг томилж сайжруулалт хийсэн.

Монгол Улсын боловсролыг ойрын жилүүдэд Дэлхийн хөгжилтэй улс орнуудын боловсролын хөгжлийн жишигт ойртуулж, тухайн түвшинд хүргэх үйл хэрэгт Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн судалгаа, шинжилгээ, хүний нөөц, материаллаг болон үйлийн орчин, дотоод, гадаад хамтын ажиллагаа, түншлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар цаашид өндөр бүтээмж, санаачилгатай ажиллах болно.

Эрдэм боловсрол, шинжлэх ухааны төлөө хамтран ажиллагч, түншлэгч Эрхэм хүндэт Та бүхэн болон Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хамт олонд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.

Боловсролын шинжлэх ухааны судалгаа, инноваци цэцэглэн хөгжих болтугай.

Хүндэтгэсэн:
Захирал доктор (Ph.D) М.Итгэл

НЭГ. БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ) нь 1956 онд сурган хүмүүжүүлэх судалгааны ажил эрхлэх, багш нарт мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилготой Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нэртэйгээр байгуулагдсан ба 1963-1991 онд Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн, 1991 оноос өнөөг хүртэл Боловсролын хөгжлийн хүрээлэн, Боловсрол судлалын үндэсний хүрээлэн, Боловсролын хүрээлэн, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн гэсэн нэрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн ажлыг тасралтгүй 60 гаруй жилийн турш явуулж ирсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 407 тоот тогтоолоор “Боловсролын хүрээлэн”-г “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болгон өргөтгөж, 2022 оны БСШУ-ы сайдын А/10 тушаалаар дүрэм, бүтцийг шинэчлэн баталсан байна. Эдүгээ тус хүрээлэн судалгааны 6 сектор, үйл ажиллагааны 2 төв, 2 албатайгаар боловсролын судалгааны ажил гүйцэтгэж байна.

Зураг 1. БСҮХ-ийн бүтэц



Тус хүрээлэн Боловсролын ерөнхий хуулийн¹ 17.2-т заасан “... боловсролын бодлогын суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн болон сургалт эрхлэх чиг үүргийн хэрэгжүүлнэ”. Мөн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн² 10.4-т зааснаар тухайн хуулийн 7.3, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, мөн Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэгтэй болно.


¹ Төрийн мэдээлэл, 2023 оны 07 дугаар сарын 24 (1275)

² Мөн тэнд

ХОЁР. БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТЭМҮҮЛЭЛ

АЛСЫН ХАРАА: БИДНИЙ АЛСЫН ХАРАА: Боловсролыг сайн сайхан нийгэм рүү хөтлөх судалгааны хүрээлэн байна.

1. БИДНИЙ ФИЛОСОФИ:



2. БИДНИЙ ХАНДЛАГА:

	Алсын зорилго үгүй бол ойрын зовлон эхэлнэ.	Сэтгэлдээ багтааж чадвал их багын ялгаагүй.	Хорвоогийн бүх өнгө хоёр чавхдаст багтана.
	Менежмент	Дижитал ертөнц	Системийн онол
	Хэмжихгүй бол удирдахгүй. Байгууллагын соёл нь эрхэм зорилго.		Сэтгэдэг систем
	Key Performance Indicator (KPI)	Objective Key Result (OKR)	Draw your system Before your think.

3. БИДНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН:

Систем			
Нэр	Статик (Static)	Динамик (Dynamic)	Фрактал (fractal)
Бүтэц	<p>Эрдэм {хэрэв \square, Δ^2 бол \square}</p> <p>Мэдлэг {$\square - \Delta^2$ $\square \Delta = \square$}</p> <p>Мэдээлэл {$\square \Delta \square \square$}</p> <p>Өгөгдөл {$\dots$}</p>		
Чанар	Агуулга Үл хөдлөх	Хугацаа Амьсгалдаг	Код Төгс

ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ, ЗАРЧИМ

Бодлого, төлөвлөлтийн болон боловсролын онол, арга зүйн үндэс, Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилт болон боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт мөн “Боловсролын хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөө 2018-2022”-ний хэрэгжилт, туршлага, сургамжийг үндэслэн БСҮХ-ийн 2023-2027 онд баримтлах Эрхэм зорилго, үнэт зүйл, зарчмыг тодорхойллоо.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын боловсролын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлж, Монгол хүний хөгжилд хувь нэмэр оруулна.

ҮНЭТ ЗҮЙЛ

ЧАНАРТАЙ СУДАЛГАА

- Боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа

СУДАЛГААНЫ УР ЧАДВАР, ЧАДАВХ

- Үндэсний хэмжээнд судалгаа хийх чадвар, зах зээлд өрсөлдөх, улмаар тэргүүлэх чадвар

ТУРШЛАГА

- 60 жилийн хугацаанд тасралтгүй ажиллаж ирсэн арвин туршлага

ХҮМҮҮНЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Олон Улсын түвшинд хамтран ажиллах чадвар, чадавх

МЭДЛЭГТ СУУРИЛСАН ШИНЖЛЭХ УХААНЧ ХАНДЛАГА

- Мэдээллийг боловсруулах, шинэ мэдлэг бүтээх суралцагч байгууллага

ҮНЭТ ЗҮЙЛ

ШИНЖЛЭХ УХААНЧ БАЙХ ЗАРЧИМ

- Орчин үеийн шинжлэх ухааны үзэл баримтлал, арга зүйг хэрэглэх;
- Судалгаа баталгаа, нотолгоотой байх;
- Бүтээл үр өгөөжтэй байх;

ХҮМҮҮНЛЭГ БАЙХ ЗАРЧИМ

- Хувь хүний болон хамт олны хүсэл эрмэлзлийг хүндэтгэх;
- Эрдэм, судалгааны академик эрх чөлөө, ёс зүйг дээдлэх;
- Бүтээгдэхүүн нь хүний болон байгаль, нийгмийн сайн сайханд зориулагдсан байх;

ЧАНАРТАЙ, ҮР АШИГТАЙ БАЙХ ЗАРЧИМ

- Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь боловсролын үйлчилгээний чанарын шаардлагыг хангах;
- Боловсрол, сургалтын судалгаа арга зүйгээр боловсролын салбарын бүх шатны ажилтнуудад үйлчлэх;
- Боловсролын судалгааны мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах;

ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2023-2027 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

БСҮХ-ийн эрхэм зорилго, үнэт зүйлсийг үндэслэн 2023-2027 онд стратегийн зургаан зорилгын хүрээнд 19 зорилт дэвшүүлсэн болно.

Зураг 3. БСҮХ-ийн зорилго



Стратегийн зорилгын хүрээнд тодорхойлсон 18 зорилтыг хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг энэхүү төлөвлөгөөний “Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн” хэсэгт авч үзсэн болно.

Хүснэгт 4. 2023-2028 оны зорилго, зорилт, үйл ажиллагааны товчоон

№	Зорилго	Тоогоор		Хувиар	
		Зорилт	Үйл ажиллагаа	Зорилт	Үйл ажиллагаа
1	Эрдэм судлалд түүчээлэгч	5	31	26.3	35.2
2	Боловсролын чанарыг эрхэмлэгч	4	21	21.1	23.9
3	Ёс зүйтэй түншлэгч	3	10	15.8	11.4
4	Шинийг санаачлагч	3	11	15.8	12.5
5	Хүний нөөцийг хөгжүүлэгч	2	8	10.5	9.1
6	Тогтвортой хөгжлийг дэмжигч	2	7	10.5	8.0
	Бүгд	19	88	100	100

1. ЭРДЭМ СУДЛАЛД ТҮҮЧЭЭЛЭГЧ

Бид боловсролын судалгааны амжилт гаргана.

1.1. Үндэсний нэгдмэл үнэт зүйлтэй, соёлын дархлаатай Монгол хүний хөгжилд боловсролын оруулах хувь нэмрийг тодорхойлно.

1.2. Боловсролын судалгааны жишиг стандарт (шаардлага) -ыг бий болгоно.

1.3. БСҮХ-ийн судалгааны тэргүүлэх чиглэлээр боловсролын салбарын бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, судалгааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.

1.4. БСҮХ-ийн чадавхыг бэхжүүлнэ.

2. БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ

Бид боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дэмжих болно.

2.1. Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлнэ.

2.2. Бүх түвшний мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг сайжруулж агуулгыг шинэчлэн боловсруулна.

2.3. Багшийн чадамжийн хүрээ тодорхойлох замаар боловсролын бүх түвшний багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжинэ.

2.4. Боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бүх шатны боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

3. ЁС ЗҮЙТЭЙ ТҮНШЛЭГЧ

Бид дотоод, гадаад хамтын ажиллагааны хариуцлагатай, найдвартай хамтрагч байна.

3.1. Олон улс болон үндэсний судалгааны байгууллагуудтай боловсролын судалгааны чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.2. Боловсролын судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үндэсний болон орон нутгийн боловсролын байгууллага, сургуулиудтай хамтран ажиллана.

3.3. Боловсролын салбарт салбар дундын хамтарсан судалгааг хөгжүүлнэ.

4. ШИНИЙГ САНААЧЛАГЧ

Бид шинэ санаа, инновацт бүтээл, дижитал технологийг дэмжинэ.

4.1. Шинэ санаа, бүтээл, инновац хөгжүүлэх менежментийг бүрдүүлнэ.

4.2. Цахим суралцахуйн арга зүйг хөгжүүлнэ.

4.3. Шинэ технологийг аюулгүй нэвтрүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааг оновчтой болгоно.

5. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ

Бид бүх түвшинд хүний нөөцийг чадавхжуулна.

5.1. БСҮХ-ийн хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.

5.2. Үндэсний түвшинд боловсрол судлаачдын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.

6. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ

Бид тогтвортой хөгжлийн үзэл санааг хөгжүүлнэ.

6.1. Тогтвортой хөгжлийн үзэл санааг үйл ажиллагаандаа тусгана

6.2. Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага болно.

ТАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 1. ЭРДЭМ СУДЛАЛД ТҮҮЧЭЭЛЭГЧ (5 зорилт, 31 үйл ажиллагаа)													
1.1.	Үндэсний нэгдмэл үнэт зүйлтэй, соёлын дархлаатай Монгол хүний хөгжилд боловсролын оруулах хувь нэмрийг тодорхойлно. Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч Монгол хүнийг төлөвшүүлэхэд боловсролын оруулах хувь нэмрийг тодорхойлно.	1.1.1.	Монголын боловсролын үнэт зүйлийн тодорхойлох	Боловсролын үнэт зүйлийн ангилал	“Монгол суралцагчийн үнэт зүйл” судалгааны тайлан 2022	Монголын боловсролын үнэт зүйлийн ангилал, харгалзах үнэт зүйлс тодорхой болсон байна.	+	+				Захирал	БТСС
		1.1.2.	Монголын боловсролын философийн судалгааг хөгжүүлэх	Философийн судалгааг хөгжүүлэх арга зам, шийдэл	“Боловсролын философи” нэг сэдэвт бүтээл, 2012	Монголын боловсролын философийн хөгжлийн үе шатууд тодорхой болсон байна. Үе шат бүрийн хувьд тодорхой шийдэлтэй бүтээлүүд гарсан байна.	+	+	+	+	+	БТСС	Бусад сектор
		1.1.3.	Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг боловсролын бүх түвшний сургалтын агуулга, арга зүйд шингээн судлах боломж, арга замыг тодорхойлох	Суралцагчдын үнэт зүйлийн төлөвшлийг тодорхойлох арга зүй	“Монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлогийн суурь судалгааны тайлан” 2019-2021	Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг сургалтын агуулга арга зүйгээр дамжуулан суралцагчдад эзэмшүүлэх арга зүйн санал тодорхой болсон байна. Агуулга арга зүйд туссан байдлын судалгаа	+	+				ХХСС	СХҮСБСС
		1.1.4.	“Монгол үндэсний өв соёлыг тээгч” иргэнийг төлөвшүүлэх агуулга, арга зүйг боловсролын бүх түвшинд нэвтрүүлэх, үнэлэх арга зүйг хөгжүүлэх	Үндэсний өв соёлыг тээгч иргэний шинж, шалгуур үзүүлэлт Нэвтрүүлсэн арга зам	Бэлэн бус	Судалгааны тайлан Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгаж үнэлэх аргачлал тодорхой болсон байна.	+	+	+			СХҮСБСС	ХХСС Сургалтын хөтөлбөр боловсруулах судлагдахууны баг
		1.1.5.	Боловсролд системийн шинжилгээ хийж боловсролын бүтэцчилсэн хүрээг тодорхойлох	Тогтолцооны зураглал, бүтэцчилсэн хүрээ	Бэлэн бус	Шинжилгээний тайлан	+	+				Захирал	БТСС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
1.2.	Боловсролын судалгааны жишиг стандарт (шаардлага) -ыг бий болгоно.	1.2.1.	Боловсролын судлаачийн ёс зүй, судалгаанд тавих шаардлагыг боловсруулах, баталгаажуулах	Судлаачийн ёс зүйн шинэ дүрэм	БСҮХ-ийн ЭША-ны ёс зүйн дүрэм	Судлаачийн судалгаа, арга зүйн үйл ажиллагаанд тавих ёс зүйн шаардлагыг тодорхойлсон байна	+					Ёс зүйн хороо	
		1.2.2.	Боловсролын судалгааны бүтээлийн ангилал, тавих шаардлагыг боловсруулах	Ангилал, түүний стандарт	Бэлэн бус	Ангилал, түүнд орох бүтээлийн нэрс, стандарт тодорхойлогдсон байна.	+					ЭНБД	Ёс зүйн хороо
		1.2.3.	Боловсролын судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, судалгааны мэдээллийн нээлттэй цахим сан бий болгох;	Цахим сан үүссэн байдал Санд орсон бүтээлийн тоо, хэмжээ			Судалгааны цахим сан	+	+	+	+	ӨБЦХСС	EdTech компани, ИДС
		1.2.4.	Боловсрол судлаачийн чадамжийг тодорхойлох	Чадамжийн хүрээ	Бэлэн бус	Боловсрол судлаачийн чадамжийн хүрээг ОУ-ын түвшинд баталгаажуулсан байна.	+					Захирал	БТСС
		1.2.5.	Боловсрол судлаачийн хөгжлийн түвшинг үнэлэх аргачлал боловсруулах	Бенчмарк		Боловсрол судлаачийн чадамжийн хүрээнд суурилсан бенчмарк тодорхойлогдсон байна.	+					Захирал	Бусад сектор
1.3.	БСҮХ-ийн судалгааны тэргүүлэх чиглэлээр боловсролын салбарын бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга	1.3.1.	Боловсролын судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Тэргүүлэх чиглэлийн жагсаалт	Бэлэн бус	2030 он хүртэлх Боловсролын судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоосон байна	+				ЭНБД	Бусад сектор	
		1.3.2.	Судалгааны үр дүн боловсролын бодлого, шийдвэрт үр нөлөө үзүүлж буй байдлыг тодорхойлох /тоогоор/ тооцох	Судалгааны үр дүнд гарсан бодлого шийдвэрийн тоо Үр нөлөөг тооцох аргачлал	Бэлэн бус	Үр нөлөөг тооцох аргачлал гарсан байна	+	+	+			БЭЗМС	БШУЯ, Мэргэжлийн байгууллага

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
замыг тодорхойлж, судалгааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.	1.3.3.	Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурлыг жил тутам зохион байгуулах	Зохион байгуулсан ЭШХ-ын тоо, хүрээ Монгол хүүхэд судлалын хурал.	"Оны шилдэг илтгэл" шалгаруулах үндэсний хэмжээний ЭШХ (IEEE ISCSSET-2024) Олон Улсын симпозиум	Эрдэм шинжилгээний хурлуудын эмхэтгэл		+	+	+	+	ЭНБД ХХСС ӨБЦХСС	Бусад хамтрагч байгууллага
	1.3.4.	"Боловсролын судалгааны Монгол сэтгүүл"-ийн чанарыг сайжруулах, олон улсын сэтгүүлийн чанар, стандартад нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Төлөвлөгөө, Олон улсын сангийн бүртгэл	Бэлэн бус	5 жилийн төлөвлөгөө гарсан байна. Олон улсын 2-оос доошгүй санд бүртгэгдсэн байна.	+	+	+	+	+	Сэтгүүлийн редакц	Бусад сектор
	1.3.5.	Боловсролын эдийн засгийн үр өгөөж, санхүүжилтийг тооцох болон боловсролын ирээдүйн хөгжлийг тодорхойлох судалгааг үе шаттай, уялдаа холбоотой зохион байгуулах	Судалгааны тайлан	Хувьсах зардлын тооцоолол судалгаа Боловсролын ирээдүйн чиг хандлага өгүүлэл	Боловсролын тодорхой асуудлаар үр өгөөжийн болон ирээдүйн чиг хандлагын судалгааны тайлан гарсан байна		+	+	+	+	БЭЗМС БХИСС	Бусад сектор
	1.3.6.	Сурах бичгийн хэрэглээний судалгааг хоёр жил тутам хийх (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ хөтөлбөрийн код 3.2.4.2)	1-12 дугаар ангийн бүх сурах бичиг	БШУ-ны сайдын захиалгаар хийсэн судалгаа (2022)	Судалгааны үр дүнг сурах бичгийн сайжруулалтад ашиглана. Судалгааны тайлан гарсан байна.	+		+			СХҮСБСС	ХХСС Бүх түвшний сургалтын байгууллага

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
1.3.		1.3.7. Хүүхдийн цогц хөгжлийн судалгаа хийж, хүүхдийн хөгжлийн жишиг үзүүлэлтүүдийг гурван жил тутамд тодорхойлох (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ хөтөлбөрийн код 3.1.1.5)	6-18 насны хүүхдийн цогц хөгжлийн бенчмарк	Бэлэн бус	Бенчмарк батлагдсан байна			+			ХХСС	
		1.3.8. Эцэг эхийн ур чадварыг үнэлэх суурь судалгаа хийх (БСХДХТ-ний үр дүнгийн матриц, үйл ажиллагаа 2.1.2.1)	Суурь судалгаа Эцэг, эхийн ур чадварын түвшин, хувь	Бэлэн бус	Суурь судалгаа хийгдсэн байна						ХХСС	
		5 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийн судалгааг гурван жил тутамд зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн үндэсний жишиг (бенчмарк)-ийг тогтоох (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ хөтөлбөрийн код 2.1.4.1)	0-5 настай хүүхдийн хөгжлийн судалгааны бенчмарк (танин мэдэхүй, биеийн хөгжил, сэтгэл хөдлөл)	Бэлэн бус	Бенчмарк батлагдсан байна	+	+	+			ХХСС	СХҮСБСС
		1.3.9. 5 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийн судалгааны үр дүнг СӨБ-ын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад тусгах (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ хөтөлбөрийн код 2.1.4.2)	Шинэчлэгдсэн хөтөлбөр, арга зүй, сургалтын материал, багшийн сургалтын хөтөлбөрийн тоо	Бэлэн бус	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах зөвлөмж гарсан байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулга гарсан байна	+	+	+			СХҮСБСС	ХХСС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		1.3.10. Хүүхдийн хөгжлийн талаар тогтоосон үндэсний жишиг үзүүлэлт (бенчмарк)-д үндэслэн хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх (БСХДХТ-ний үр дүнгийн матриц, Хөтөлбөр 2.1.2.4)	Хүүхэд хөгжлийн оноо	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай						ХХСС	СХҮСБСС
		1.3.11. Иргэдийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээг тодорхойлох үндэсний хэмжээний судалгаа зохион байгуулж, суралцахуйн хэлбэр, төрөл, агуулгыг ҮМХ-тэй нийцүүлэн тодорхойлох (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ, хөтөлбөрийн код 1.2.1.1)	Судалгааны арга зүй		Судалгааны тайлан Насан туршийн суралцахуйн хэлбэр, төрөл, агуулгыг ҮМХ-тэй нийцүүлэн тодорхойлсон байна.		+	+	+	+	СХҮСБСС	ХХСС БМИҮЗ БҮТ
		1.3.12. Төрөлжсөн ахлах сургууль байгуулах хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийх; төрөлжих чиглэлүүдийг тодорхойлох (БСХДХТ-ний үр дүнгийн матриц, Хөтөлбөр 2.1.2.4)	Ахлах сургуулийн хэрэгцээний судалгаа	Бэлэн бус	Ахлах сургуулийг хөгжүүлэх бодлогын чиглэл, цаашид авах арга хэмжээ тодорхойлогдсон байна.		+	+	+		СХҮСБСС	БТСС Их, дээд сургууль, ЕБС, Төв аймгийн Политехник коллеж
1.4.	Боловсролын салбарын хүний нөөцийн чадамжийн хүрээг тодорхойлно.	1.4.1. Багшийн хөгжлийн чадамжийн хүрээг тодорхойлох	Чадамж, бенчмарк	Ажлын байрны тодорхойлолт	Цэцэрлэг, ерөнхий, мэргэжлийн, дээд багшийн чадамжийн хүрээ тодорхойлогдсон байна.		+	+	+	+	БТСС	СХҮСБСС
		1.4.2. Удирдах ажилтны чадамжийн хүрээг тодорхойлох	Чадамж, бенчмарк	Ажлын байрны тодорхойлолт	СӨБ болон ЕБ-ын удирдах ажилтны чадамжийн хүрээ тодорхойлогдсон байна.			+	+		БТСС	СХҮСБСС
		1.4.3. Боловсролын салбарын зарим ажилтны чадамжийн хүрээг тодорхойлох	Чадамж, бенчмарк	Ажлын байрны тодорхойлолт	ЕБ-ын нийгмийн ажилтны чадамжийн хүрээ тодорхойлогдсон байна.				+	+		БТСС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж			
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж		
1.5.	БСҮХ-ийн чадавхийг бэхжүүлнэ.	1.5.1.	БСҮХ-ийн үйл ажиллагааны чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор процессын зураглал (process mapping)-ыг боловсруулах	Процессын зураглал	Бэлэн бус	Процессын зураглал гарч, үйл ажиллагааны чанар сайжирсан байна.		+				Захиргааны зөвлөл, дэмжих алба		
		1.5.2.	БСҮХ-ийн судалгаа, арга зүйн үйл ажиллагааг үндэсний түвшинд түгээх, хэрэгжүүлэх СӨБ, ЕБС, МБСБ-иудад түшиглэсэн бүтцийг бий болгох	Хүүхэд судлалын албан бус нэгдэл буй болсон байна. Түшиц сургуулийн тоо	Бэлэн бус	Хүүхдийн хөгжлийн оношилгоо зөвлөгөө өгөх төв байгуулагдах СӨББ, ЕБС, МБСБ-ын түвшинд Түшиц сургуультай болсон байна.		+	+		+	+	ХХСС Захирал БТСС	БСҮХ, Захиргаа, дэмжих баг
		1.5.3.	БСҮХ-ийн түшиц цэцэрлэг, сургууль байгуулах, баримтлах шалгуур, шаардлагыг боловсруулах, баталгаажуулах	Түшиц сургуульд тавих шаардлага, шалгуур	Бэлэн бус	Шаардлага, шалгуур батлагдсан байна.		+					БТСС	Бусад сектор
		1.5.4.	БСҮХ-ийн дэргэд байгуулах мэргэжлийн боловсролын сургалт, арга зүйн төвийг байгуулах	Бүтэц бий болсон эсэх	Бэлэн бус	Мэргэжлийн боловсролын сургалт, арга зүйн төв ажиллаж эхэлсэн байна		+					Захирал, захиргааны зөвлөл	БШУЯ

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 2. БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ (4 зорилт, 21 үйл ажиллагаа)													
2.1	Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлнэ.	2.1.1.	Үнэт зүйл, чадамжид суурилсан боловсролын хандлагад тулгуурлан боловсролын бүх түвшний суралцагчийн дүр төрх, чадамжийг тодорхойлох	Суралцагчийн чадамжийн жагсаалт, монгол хүүхдийн дүр төрх	Ерөнхий боловсролын судлаг-дахууны хөтөлбөр бүрээр шинжилгээ хийсэн.	Суралцагчийн чадамжийг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулахад судалгааны үр дүнг тусгасан байна.	+	+	+	+	СХСБҮСС БҮТСС	Бусад сектор	
		2.1.2.	Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах (суралцахуйн универсаль дизайн (UDL)-ы үзэл санааг тусгах)	Хэлэлцүүлгийн тоо, хамрах хүрээ	Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг төслийг БҮЗ-өөр хэлэлцүүлж байна.	Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдсан байна.	+	+			СХҮСБСС	Үндэсний зөвлөл, Бусад сектор	
		2.1.3.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах	Сургалтын хөтөлбөрийн тоо	Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол (бага, дунд ахлах анги)-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна	+	+	+	+	+	СХҮСБСС	Мэргэжлийн бай-гууллага Бүх түвшний сургалтын байгууллагын төлөөлөл
		2.1.4.	Сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах аргачлал гаргах;	Сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэйгээр боловсруулах арга зүй	Бэлэн бус	Сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах аргачлал гарсан байна.	+	+				СХҮСБСС	Жендэрийн үндэсний хороо
		2.1.5.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан сургалтын хөтөлбөрт шаардлагатай ур чадваруудын судалгаа хийж, хөтөлбөрийн хөгжүүлэлтэд ашиглаж хэвших	Судалгааны арга зүй Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай суралцагчийн ур чадварын жагсаалт	Сургалтын хөтөлбөрт туссан чадамжийн судалгааны тайлан	Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай суралцагчийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөртэй болсон байна.	+	+	+	+	+	СХҮСБСС	Бусад секторууд Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөлөл

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		2.1.6. Хүүхдийн хөгжлийг дэмжих, эцэг эхийн сургалтын багц жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, түгээх Дээрх сургалтуудыг орон нутгийн боловсролын газар, насан туршийн боловсролын төвүүдэд тулгуурлан зохион байгуулах (Үйл ажиллагаа 2.1.2.3)	Боловсруулсан хөтөлбөрийн тоо Түгээн дэлгэрүүлсэн сургалтын тоо	Бэлэн бус	Эцэг эхэд зориулсан сургалтын хөтөлбөртэй болсон байна. Түгээн дэлгэрүүлэх механизм бүрдсэн байна.	+	+	+	+	+	ХХСС БХИССС СХУСБСС,	БЕГ, НТБХ, НТБТ
		2.1.7. Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн дагуу тасралтгүй мэдээлэл цуглуулж, сургалтын хөтөлбөр судлал (СХС)-ыг шат дараатайгаар хөгжүүлэх	СХ, түүний хэрэгжилтийг судлах судалгааны арга зүй, СХС-ын ЭШ-ний бүтээлийн тоо	ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал	Сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг судлах судалгааны арга зүйтэй болсон байна. Сургалтын хөтөлбөрийн судалгааг тасралтгүй, үр дүнтэй хийж хэвшсэн байна.	+	+	+	+	+	СХУСБСС	Бусад секторууд БЕГ БҮТ
		2.1.8. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах үүднээс үндэсний сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга, зүйн зөвлөмж, гарын авлага боловсруулах	Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн зөвлөмж, гарын авлага-тоо	Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тэгш хамруулах үзэл санаа тусгагдсан.	Үндэсний сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн зөвлөмж, гарын авлага боловсруулсан байна.	+	+	+	+	+	СХУСБСС	Бусад секторууд, БЕГ, БҮТ, Их, дээд сургууль, Судлаачид
		2.1.9. Сургалтын хөтөлбөр боловсруулагчдыг чадавхжуулах ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо, хамрах хүрээ, оролцогчдын тоо	ЮНЕСКО- IBE болон Кембрижийн зөвлөх үйлчилгээний хүрээнд СХ, СБ боловсруулагчдыг чадавхжуулах цахим болон танхимын сургалт (4 удаа)	Үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулахад хамтран ажиллах чадамжтай хүний нөөц бүрдсэн байна.	+	+	+	+	+	СХУСБСС	Бусад секторууд, БЕГ, БҮТ, Их, дээд сургууль, Судлаачид

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж			
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж		
		2.1.10	Монгол хэлний сургалт, түвшин тогтоох үнэлгээний системийг хэрэгжүүлж, боловсролын бүх түвшинд нэвтрүүлэх (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ, хөтөлбөрийн код 1.1.1.2)				+	+	+			Монгол хэлний төв	БШУЯ	
		2.2.1.	Цахим ур чадвар, чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох	Чадамжийн бүтцийн хүрээ	Бэлэн бус	Бүх нийтийн МХХТ-ийн чадамжийн бүтцийн хүрээ батлагдсан байна.	+					ӨБЦСХС БХИССС		
2.2	Бүх түвшний мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг сайжруулж агуулгыг шинэчлэн боловсруулна	2.2.2.	Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийн олон улсын харьцуулсан судалгаа хийх (ерөнхий боловсролын түвшинд)	Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээ	Бэлэн бус	Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөр боловсруулахад хэрэгцээт агуулгын хүрээ, судалгааны мэдээлэлтэй болсон байна.	+	+				СХҮСБСС	ӨБЦСХС И-Монголиа академи Их, дээд сургууль БМТТ	
		2.2.3.	Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөр, агуулгыг олон улсын түвшинд хүргэж, шинэчлэн боловсруулах	Сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага	Бэлэн бус.	Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөр боловсруулагдсан байна.							СХҮСБСС	ӨБЦСХС
		2.2.4.	Насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийн цахим ур чадвар олгох агуулгыг шинэчлэн боловсруулах	Насанд хүрэгчдэд зориулсан МХХТ-ийн сургалтын жишиг хөтөлбөр	Суурь болон БДБ нөхөн олгох МХХТ-ийн сургалтын хөтөлбөр	Зорилтот бүлгүүдэд зориулагдсан МХХТ-ийн боловсролын модуль хөтөлбөрүүд боловсруулагдсан байна	+	+	+	+	+		БХИССС ӨБЦХСС холбогдох ЭША	Цахим хөгжлийн яам, И-Монгол Академи" БЕГ

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
2.3	Багшийн чадамжийн хүрээ тодорхойлох замаар боловсролын бүх түвшний багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжинэ.	2.3.1.	Ерөнхий боловсролын багшид тавигдах мэргэжлийн ерөнхий шаардлага буюу багш мэргэжлийн стандарт боловсруулах	Багш мэргэжлийн стандарт, ерөнхий шаардлага	Бэлэн бус	Стандарт, шаардлага хангасан багшийн тоо нэмэгдсэн байна.		+				БТСС	БЕГ
		2.3.2.	Шинээр багш бэлтгэх, багшийн мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Багш бэлтгэх, багшийн мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтын хөтөлбөр	Бэлэн бус	Шинээр багш бэлтгэх, багшийн мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтын хөтөлбөр батлагдсан байна.		+		+		БТСС, БХИСС	МУБИС, бусад багш бэлтгэдэг их дээд сургууль
		2.3.3.	Хос хэлээр сургалт зохион байгуулдаг сургуулийн багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтын модуль боловсруулах	АХИС-ын арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалт, хамрагдсан багшийн тоо	СХ-ийн үзэл баримтлалд тусгасан	Хэл соёлын ялгаатай хэрэгцээт суралцагчдад сургалт зохион байгуулах багшлах боловсон хүчин, хүний нөөц бэлтгэгдсэн байна.		+	+	+	+	+	СХСБҮСС ХХСС
2.4	Боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бүх шатны боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.	2.4.1.	ЕБС-ийн бага ангийн сурах бичгүүдийг интерактив хэлбэрт шилжүүлэх	Интерактив хэлбэрт шилжүүлсэн бага ангийн сурах бичгийн тоо	Бэлэн бус	ЕБС-ийн бага ангийн 33 сурах бичгийг интерактив хэлбэрт шилжүүлсэн байна.		+	+			СХСБҮСС	БМТТ
		2.4.2.	Суралцагчийн зөөлөн ур чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэх арга хэрэгслийг боловсруулж, турших	Суралцагчийн зөөлөн ур чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэх арга хэрэгсэл	БҮТ-ийн үнэлгээний даалгаврын сан	Суралцагчийн зөөлөн ур чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэх туршигдаж, баталгаажсан арга хэрэгсэлтэй болсон байна.		+	+	+	+		СХҮСБСС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		2.4.3. ЕБС-ийн менежментийн загвар, зөвлөмж боловсруулах, түгээн дэлгэрүүлэх	ЕБС-ийн менежментийн сургалт, хамрагдсан оролцогчдын тоо	ЕБС-ийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж	ЕБС-ийн менежментийн загвар, зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх замын зураглалын дагуу хийх хэвшсэн үйл ажиллагаатай болсон байна.	+	+	+				БШУЯ БЕГ БҮТ
		2.4.4. Монгол улсын мэргэшлийн үндэсний хүрээг (ҮМХ) боловсруулахад бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Монгол улсын мэргэшлийн үндэсний хүрээ боловсруулах арга зүй, аргачлал	ҮМХ-г бий болгож, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг, судалгааны тайлан гарсан.	Монгол улсын мэргэшлийн үндэсний хүрээ гарсан байна.	+	+					СХҮСБСС БМИҮЗ Их, дээд сургууль

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 3. ЁС ЗҮЙТЭЙ ТҮНШЛЭГЧ (3 зорилт, 10 үйл ажиллагаа)													
3.1	Олон улс болон үндэсний судалгааны байгууллагуудтай болговсролын судалгааны чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	3.1.1.	Боловсролын судалгааны арга зүйг хэлэлцүүлэх ажлыг хамтрагч талуудын оролцоотой зохион байгуулах	Хамтран хэлэлцсэн судалгааны арга зүйн тоо	Бэлэн бус	Хамтрагч талууд тодорхой болж, арга зүй хэлэлцэх механикч бүрдсэн байна.	+	+	+	+	+	БСҮХ-ийн удирдлага, ӨЗ	Секторууд
		3.1.2.	Боловсролын судалгааны шинэлэг арга зүй, мэдээлэл цуглуулах хэрэгслийг холбогдох болон хамтрагч талуудын оролцоотой боловсруулах	Мэдээлэл цуглуулах хэрэгсэл	www.survey .mn	Веб-д суурилсан мэдээлэл цуглуулах программ хангамж, анхдагч мэдээллийн сан		+		+		ӨБЦСХС	EdTech компани
		3.1.3.	Гадаадын боловсролын судалгааны байгууллагуудтай зочин эрдэмтэн урих, цахим сургалт, хамтарсан төсөл хэрэгжүүлэх замаар олон улсын сүлжээ, түншлэлийг өргөжүүлэх;	Хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоо Олон улсын түншлэл, сүлжээнд оролцсон байдал	Бэлэн бус	Хамтарсан судалгааны тоо нэмэгдэж, боловсролын судалгаы олон улсын баг бий болох эхлэл тавигдана.		+	+	+	+	Эрдмийн зөвлөл Захиргааны зөвлөл	Секторууд, төвүүд
		3.1.4.	Их сургуулиудтай судалгааны харилцаагаа өргөжүүлж, ахисан түвшний сургалтад хамтарсан хичээл санал болгох ба багшийн хөгжлийн төвийг байгуулахад хамтран ажиллах	Боловсрол судлалаар хамтарсан сургалт зохион байгуулна.	Бэлэн бус	Боловсрол судлалын чиглэлээр гадаад дотоодын эрдэмтэн судлаачтай хамтран тогтмол сургалт хэлэлцүүлэг зохин байгуулдаг болно.		+	+	+	+	ХХСС	
3.2	Боловсролын судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үндэсний болон орон нутгийн боловсролын байгууллага, сургуулиудтай хамтран ажиллана.	3.2.1.	Боловсролын үндэсний байгууллагуудыг (БЕГ, БҮТ...) судалгааны арга зүйгээр хангах, ажилтнуудыг чадавхжуулах	Судалгааны арга зүйгээр хангасан ажилтнуудын тоо	Бэлэн бус	Судалгааны арга зүй хамтран боловсруулах, ажилтнуудыг чадавхжуулах тогтолцоо бүрдсэн байна.		+	+	+	+	Секторууд	Мэргэжлийн байгууллагууд
		3.2.2.	Орон нутгийн боловсролын байгууллагын судалгааны чадавхыг дэмжих хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажиллах	ОН- түвшинд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний тоо, гэрээний дагуу зохион байгуулсан сургалт, ҮА-нд оролцогчдын тоо	Судалгааны чадавхыг дээшлүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулсан 3 сургууль,	Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан орон нутгийн боловсролын байгууллагын судалгааны чадавхыг сайжруулах сургалт зөвлөгөөг бүсүүдээр зохион байгуулах .		+	+	+	+	ХХСС	СХҮСБСС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		3.2.3. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны судалгааны арга зүйг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, зөвлөн туслах	Зохион байгуулсан сургалт, зөвлөн тусалсан үйл ажиллагааны тоо	Тодорхойгүй	Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны судалгаа хийх ур чадвар сайжирна.		+	+	+	+	Секторууд	Мэргэжлийн байгууллагууд
3.3.	Боловсролын салбарт салбар дундын хамтарсан судалгааг хөгжүүлнэ.	3.3.1. Салбар дундын судалгаа хийх чиглэлийг тодорхойлох, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Салбар дундын хамтарсан судалгаа болон холбогдох байгууллагуудын тоо	Судалгааны чиглэлээр хамтран ажилласан байгууллага, хамтран хийсэн судалгаанууд	Салбар дундын судалгаа хийх чиглэлийг тодорхойлон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах боломж бүрдсэн байна	+	+	+	+	+	БСҮХ, Секторууд	Хамтран ажиллах байгууллага, ТББ, олон нийтийн байгууллага
		3.3.2. Гамшгийн үеийн боловсрол, тэгш хамран сургах боловсролын чиглэлээр холбогдох байгууллага, хүрээлэнтэй хамтран судалгаа хийх, судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх;	Хамтарсан судалгаа болон хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	Бэлэн бус	Судалгааны тайлан, дүгнэлт, санал гарсан байна.		+		+		Холбогдох сектор	ОУБ, бусад хүрээлэн
		3.3.3. Орон нутаг, соёл, урлаг, спортын байгууллагуудын боловсролтой холбоотой санал, санаачилгын дэмжин ажиллаж шинэ түншлэлийг хөгжүүлэх	Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	Бэлэн бус	Орон нутаг, соёл, урлаг, спортын байгууллагуудтай хамтран ажиллах соёл бүрдсэн байна		+	+	+	+	БСҮХ-ийн удирдлага, дэмжих алба	Секторууд

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 4. ШИНИЙГ САНААЧЛАГЧ (3 зорилт, 11 үйл ажиллагаа)													
4.1	Шинэ санаа, бүтээл, инноваци хөгжүүлэх менежментийг бүрдүүлнэ.	4.1.1.	Боловсролын инновацид тулгуурлан суралцахуйн болон багшлахуйн загваруудыг боловсруулж, түшиц сургуулиуд дээр туршиж, үндэсний хэмжээнд дэлгэрүүлэх	Суралцахуйн болон багшлахуйд нэвтрүүлэх загварын тоо Загварыг туршсан түшиц цэцэрлэг, сургуулиудын тоо Үндэсний хэмжээнд дэлгэрүүлсэн цэцэрлэг, сургуулиудын тоо	Математикийн EDUTEN Англи хэлний PEARSON Бага ангийн 33 сурах бичгийн интерактив хувилбар LEARNETIC Цагаан толгойн хялбар аргачлал	Суралцахуйн болон багшлахуйн загварыг туршсан байна. Жил бүр түшиц цэцэрлэг, сургуулийн багш нарт сургалт зохион байгуулна. Үндэсний хэмжээнд зарим сургуульд нэвтрүүлсэн байна.	+	+	+	+	+	СХСБҮСС	БЕГ
		4.1.2.	Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих замаар ажилтан, албан хаагчдын дижитал ур чадварыг хөгжүүлэх	Ажилтан, албан хаагчдын дижитал ур чадварыг хөгжүүлэх сургалтын тоо	Бэлэн бус	Ажилтан, албан хаагчдын дижитал ур чадварыг хөгжүүлэх модуль сургалт зохион байгуулна.		+	+	+	+	ӨБЦСХС БХИССС	EdTech companies
		4.1.3.	Хүүхдийн суурь ур чадваруудыг оношлох, хөгжүүлэх аргачлалуудыг сургалтын практикт ашиглах боломжтойгоор хөгжүүлж, түшиц сургуулиудад нэвтрүүлэх	Хүүхдийн суурь ур чадваруудыг оношлох, хөгжүүлэх аргачлал бүхий гарын авлага Аргачлалыг ашиглаж буй түшиц цэцэрлэг, сургуулиудын тоо	Бэлэн бус	Аргачлалыг түшиц цэцэрлэг, сургуулиудын сургалтад ашиглаж нэвтрүүлсэн байна.		+	+	+		ХХСС СХҮСБСС	
		4.1.4.	Цахим ур чадварын үнэлгээний системийг хиймэл оюун дээр суурилж хөгжүүлэх боломж, арга замыг тодорхойлох	Тодорхойлсон арга зам, үнэлгээнд хамтрагдсан оролцогчдын тоо	Бэлэн бус	Цахим ур чадварын үнэлгээний систем боловсруулах суурь судалгааны арга зүй		+	+	+	+	БХИССС ӨБЦСХС	ОУБ БМТТ EdTech компани

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		4.1.5. Хүний нөөцийн мэргэжил дээшлүүлэх уян хатан холимог хэлбэрийн сургалтыг нээлттэй боловсрол, дижитал технологи ашиглан хөгжүүлэх нийлүүлэх (2021-2025 онд хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх ДХТ)	Онлайн болон холимог сургалтад хамрагдсан ЭША-ны тоо, сургалтын тоо	Бэлэн бус	ЭША-дад онлайн болон холимог сургалт зохион байгуулж, МХ-ийг дэмжсэн байна.	+	+	+	+	+	ӨБЦСХС	Дэмжих алба
4.2	Цахим суралцахуйн арга зүйг хөгжүүлнэ.	4.2.1. Дижитал технологийн тусламжтайгаар суралцахуй, багшлахуй, үнэлгээ, судалгааны ажилд уян хатан хандлагыг бий болгох	Дижитал технологийн аргаар суралцахуй ба багшлахуйг үнэлэх арга зүй	Бэлэн бус	ЕБС-ийн сурагчдын 10 хувийг хамруулна.		+	+	+	+	БХИССС	
		4.2.2. Суралцагчийн дижитал ур чадварт суурилсан платформ судалж, түшиц сургуулийн сургалтын практикт нэвтрүүлэх	Цахим сургалтын систем	ЕБ-ийн түвшинд хэрэглэж буй цахим сургалтын сан, цахим сурах бичиг, хэрэгсэл, платформын судалгаа	Түшиц сургуулийн сургалтын практикт цахим сургалтын системийг нэвтрүүлсэн байна.	-						ӨБЦСХС БХИССС
4.3	Шинэ технологийг аюулгүй нэвтрүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааг оновчтой болгоно.	4.3.1. Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах цахим ур чадварыг шаардлагыг тодорхойлох	Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах цахим ур чадварыг шаардлага	Бэлэн бус	Эрдэм шинжилгээний ажилтанд тавигдах цахим ур чадварын хүрээ, шаардлага батлагдсан байна		+				БСҮХ-ийн удирдлага	ӨБЦСХС
		4.3.2. Судалгааны стандартыг баримтлахад судлаачийн цахим ур чадварыг дэмжих сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Цахим ур чадварыг дэмжих сургалтын тоо, оролцогчдын тоо	Судалгааны программыг ашиглож буй судлаачдын тоо 60 хувь Статистик боловсруулалтын SSPS программын, BI"Tableau" программын сургалт	Судалгааны программ ашиглан Ахисан түвшний анализ хийх чадвартай болсон ЭША-ны тоог 20 хувиар хувиар өссөн байна.			+	+	+	+	ӨБЦСХС

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		4.3.3. БСҮХ-ийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах	БСҮХ-ийн мэдээллийн системийн модулиуд	ЭША-нуудын ажил, бүтээлийг бүртгэлжүүлж урамшуулалын оноожуулалтын систем, БСҮХ-ийн цахим сэтгүүлийн систем	БСҮХ-ийн мэдээллийн системийг нэвтрүүлсэн байдал		+	+	+	+	ӨБЦСХС	EdTech компани
		4.3.4. БСҮХ-ийн ажилтан, албан хаагчдын тасралтгүй үйл ажиллагааг хангахын тулд шаардагдах программ хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангах	Лицензтэй программ хангамжийн тоо, шинэ ашиглаж байгаа техник тоног төхөөрөмжийн тоо болон техник тоног төхөөрөмжийн үзүүлэлт	Нийт суурин ,,, зөөврийн ... компьютер байна. лицензтэй антивирусны программ болон MS-OFFICE 365 ашигладаг	Орчин үеийн техник, технологийн шаардлага нийцсэн ажлын байр, орчин		+	+	+	+	ӨБЦСХС	Дэмжих алба

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж		
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 5. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ (2 зорилт, 8 үйл ажиллагаа)													
5.1	БСҮХ-ийн хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.	5.1.1.	ЭША-ын эрдмийн цол, зэргээ ахиулахад дэмжиж ажиллах, ЭША-ыг эрдмийн зэрэг хамгаалахад аргазүйн туслалцаа үзүүлэх	Зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо Эрдмийн цол, зэрэг ахиулсан ЭША-ны тоо	Бэлэн бус	Докторант ЭША-дад арга зүйн дэмжлэг үзүүлэх механизм бүрдсэн байна.	+	+	+	+	+	Захиргааны зөвлөл БХИСС	Бүх сектор, төв
		5.1.2.	БСҮХ-ийн ЭША-г эрдмийн зэрэг цол ахиулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн санхүүжилтийн хэмжээ	Бэлэн бус	Эрдмийн зэрэг хамгаалсан ЭША-ны хувь өссөн байна.		+	+	+	+	Захиргааны зөвлөл	Бүх сектор, төв
		5.1.3.	Нийт ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэх, тэдний эрүүл мэндийг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Нийгмийн асуудлыг шийдэх болон эрүүл мэндийг дэмжих, соёл урлаг, спортын чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдалтын хувь	Тогтмолжоогүй	- Үйл ажиллагаа тогтмолжиж, хамрагдалт, идэвх оролцоо нэмэгдсэн байна. - Сэтгэл ханамж дээшилсэн байна.	+	+	+	+	+	Захиргааны зөвлөл, дэмжих үйлчилгээний алба	Бүх сектор, төв
		5.1.4.	БСҮХ-ийн залуу, дунд, ахмад үеийн судлаачид албан хаагчдын харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх, "Ахмадын зөвлөл "Үйлдвэрчний эвлэл" зэрэг сайн дурын байгууллага байгуулахыг дэмжиж ажиллах	Сайн дурын байгууллагын санал санаачилгыг дэмжсэн үйл ажиллагаа болон санхүүгийн дэмжлэг	Бэлэн бус			+	+	+	+	Захиргааны зөвлөл	Бүх сектор

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		5.1.5. БСҮХ-ийн судлаачдыг гадаадад ахисан түвшинд суралцуулах богино хугацааны сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх	Гадаадад суралцсан болон мэргэжил дээшлүүлсэн ЭША-ны тоо, хувь, дэмжлэг үзүүлсэн хэлбэр		- ЭША-дад гадаадад суралцах болон мэргэжил дээшлүүлэх тэгш боломж бүрдүүлсэн байна. -Судалгаа, арга зүйн ажлын чанар, үр дүн сайжирсан байна.	+	+	+	+	+	Захиргааны зөвлөл	Бүх сектор
		5.1.6. БСҮХ-ийн ЭША-ны хувьд гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг хэрэгжүүлэх	Урамшууллын аргачлал	Тодорхой үйл ажиллагаанд тулгуурласан аргачлал	Тодорхой үр дүнд суурилсан аргачлал бий болгож ЭША-г үнэлэн урамшуулах үйл ажиллагаа тогтмолжсон байна.	+	+	+	+	+	Захирал	Захиргааны зөвлөл
5.2	Үндэсний түвшинд боловсрол судлаачдын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.	5.2.1. Боловсрол судлаачдын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	Судлаачдын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	Сургалт	Боловсрол судлаачийн чадамжийн хүрээнд суурилан тэднийг хөгжүүлэх ажлууд хийгдсэн байна.	+	+	+	+	+	Эрдмийн зөвлөл, ЭНБД	Бусад сектор
		5.2.2. Дээд боловсролын ахисан түвшний суралцагчидтай судалгааны чиглэлээр хамтран ажиллах	Боловсрол судлалаар суралцагч оюутнуудтай хамтран ажиллах хөтөлбөр -Боловсрол судлалын чиглэлээр суралцаж буй ахисан түвшний суралцагчидтай хамтран ажиллах төлөвлөгөө		Дээд боловсролын ахисан түвшний сургалтад хичээл зааж, хамтарсан судалгаа хийнэ, удирддаг болно. ЭША их, дээд сургуулиудад гэрээгээр ажиллана.	+	+	+	+	+	БСҮХ-ийн удирдлага, ХХСС СХҮСБСС	Бусад сектор

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 6. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ (2 зорилт, 7 үйл ажиллагаа)												
6.1	Тогтвортой хөгжлийн үзэл санааг үйл ажиллагаандаа тусгана.	6.1.1.	Тогтвортой хөгжлийн үзэл санаанд тулгуурлан үндэсний соёл, түүхийг сурталчлах, хөгжүүлэх Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаанд суурилсан үндэсний уламжлалт соёл, түүхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр цахим контент боловсруулах	Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгасан үндэсний уламжлалт соёл, түүхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх цахим контент СӨБ, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгасан эсэх	ТХБ-II төслийн суурь болон үр дүнгийн судалгааны тайлан СӨБ, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт ТХ, ТХБ-ын үзэл санааг тусган хэрэгжүүлэх зөвлөмж ТХЗ-ын төлөөх боловсролыг суралцахууд интерацчилах арга зүй ном esd.mn цахим платформ	Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгасан үндэсний уламжлалт соёл, түүхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх цахим контент /...../бүтээсэн байна. Бүх түвшний сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгасан байна.	+	+	+	+	СХҮСБСС	Дэмжих алба бусад сектор
		6.1.2.	Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгах				+	+	+	+		
		6.1.3.	Боловсролын бүх түвшний сургалтад тогтвортой хөгжлийн боловсролын модулиуд боловсруулж, санал болгох	Боловсруулсан модулийн тоо	ТХБ-II хүрээнд 8 үндсэн сэдвийн хүрээнд боловсруулсан модулиуд Олон улсын баримт бичгийн эмхэтгэл	Боловсролын бүх түвшний сургалтад тогтвортой хөгжлийн боловсролын модулиудаар сургалт зохион байгуулсан байна	+	+	+	+		
6.2	Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага болно.	6.2.1.	БСҮХ-ийн ажилтан, албан хаагчдыг тогтвортой хөгжлийн төлөөлөгч болоход нь дэмжлэг үзүүлж, мэдлэг, чадварыг нь хөгжүүлэх	ЭША, албан хаагчдын мэдлэг чадварын ахиц	Бэлэн бус	БСҮХ-ийн ажилтан, албан хаагчдын ТХБ-ын мэдлэг чадвар дээшилж, судалгааны ажилд тусгах хэрэгжүүлнэ	+	+	+	+	Бүх сектор	Төсөл, хөтөлбөр, мэргэжлийн байгууллагууд
		6.2.2.	БСҮХ-ийн ажилтан, албан хаагчдын тогтвортой байдлын санаачилгыг дэмжих, оролцох боломжийг бүрдүүлэх	ТХБ, тогтвортой байдлыг дэмжсэн санаачилга, үйл ажиллагааны тоо	Бэлэн бус	Дэмжих арга зам, механизм бүрдсэн байна	+	+	+	+	Бүх сектор, Дэмжих алба	Төсөл, хөтөлбөр, хамтрагч байгууллагууд

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа					Хариуцах нэгж	
						2023	2024	2025	2026	2027	Хариуцах нэгж	Хамтрах нэгж
		6.2.3. БСҮХ-ийн ногоон оффис буюу эрүүл орчныг бүрдүүлэх, ногоон технологид суурилсан, тогтвортой хөгжлийн үндсэн зарчимд нийцүүлсэн хамтын ажиллагааны соёлыг хэвшүүлнэ.	Ажилтан, албан хаагчдад зориулсан зөвлөмж, заавар	Бэлэн бус	Ногоон худалдан авалт, ногоон оффисын менежмент бүрдсэн байна.		+	+	+	+	Бүх сектор, Дэмжих алба	Төсөл, хөтөлбөр, хамтрагч байгууллагууд
		6.2.4. Ногоон ажлын байрны стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болох	Стандартын шаардлагыг хангасан ажлын байрны тоо	MNS 7002:2023 (Байгаль орчны менежмент. Ногоон ажлын байранд хэрэгжүүлэх арга зүйн заавар)	MNS 7002:2023 Ногоон ажлын байранд хэрэгжүүлэх арга зүйн зааврыг мөрдсөн байна.		+	+	+	+	Бүх сектор, дэмжих алба	Төсөл, хөтөлбөр, хамтрагч байгууллагууд